

БИК-19



## НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
8 дугаар хороо, Лхагвасүрэнгийн гудамж,  
Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байр,  
Утас: 32-77-34, Факс: (976-11) 32-01-54,  
E-mail: ub@audit.mn; http://www.city.audit.mn

Г НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР,  
СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА  
Ж.ГАНБОЛД ТАНАА

2015. 03. 12. № 260.  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Менежментийн захидал хүргүүлэх  
тухай

Төрийн Аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Нийслэлийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын үйл ажиллагааны 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийлээ.

Санхүүгийн тайланг үнэн зөв гаргаж тайлагнах асуудал Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын удирдлагын хариуцлага бөгөөд тухайн санхүүгийн тайланд дүгнэлт гаргах үүрэг аудитын багийн үүрэг болно.

Уг санхүүгийн тайлангийн байдал болон илэрсэн зөрчлийн тухай бичигдсэн Менежментийн захидлыг хүргүүлж байна. Уг захидлын хариуг 2015 оны 3 дугаар сарын 13-ны дотор ирүүлнэ үү.


Хавсралт: Менежментийн захидал... хуудас.

ДЭД ДАРГА

Т.САРАНТУЯА



ТӨСӨЛ



## НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг  
хүсвэл дараах хаягаар  
харилцана уу:

### Т.Сарантуяа

Нийслэлийн аудитын  
газрын дэд дарга  
өрөөний утас: 327744

### Ц.Хосжаргал

Санхүүгийн аудитын II  
албаны менежер  
өрөөний утас: 315558

### Ц.Саранцэцэг

Ахлах аудитор  
өрөөний утас: 325093

## Менежментийн захидал

### Тэргүүлэх ач холбогдол №3 зүйлс:

Асуудал 1	3
Зардал.....	3
Асуудал 2	3
Бараа материал .....	3
Асуудал 3	
Өглөг.....	4

**ТАБ-ЫН ХАЯГ:** Нийслэлийн  
аудитын газар

**Байршил:** Улаанбаатар хот

Сүхбаатар дүүрэг,

Ж.Лхагвасүрэнгийнгудамж,

Нийслэлийн засаг

захиргааны V байр

E mail: [ub@audit.mn](mailto:ub@audit.mn)

Вэб хаяг: [www.city.audit.mn](http://www.city.audit.mn)

2015 оны 3 дугаар сар 11

## Менежментийн захидал

Нийслэлийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Нийслэлийн биеийн тамир, спортын газрын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандартын дагуу хийгддэг төрийн аудитын байгууллагын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Нийслэлийн Аудитын газар та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Нийслэлийн биеийн тамир, спортын газрын санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

**Асуудал 1: Зардал**

**Тэргүүлэх ач холбогдол №3**

**НАГ-ЫН АЖИГЛАЛТ**

Өглөгийн дансаар дамжуулалгүй 665.5 мянган төгрөгийн гүйлгээг зардалд шууд тусгасан нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 3.10 дахь заалттай нийцэхгүй байна..

Мөн байгууллагууд руу дамжуулан гаргаснаас бусад өөрийн байгууллагын хариуцан зохиосон спортын арга хэмжээний зардлын гүйлгээг мөнгөн урьдчилгааны дансанд бүртгээгүй, зардалд шууд тусгасан байна.

**Эрсдэлүүд**

Санхүүгийн тайланд авлага, өглөг дутуу тусгагдах, мөнгөн хөрөнгө шамшигдах

**НАГ-ЫН ЗӨВЛӨМЖ**

Цаашид ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулан бүртгэж байх

Мөнгөн урьдчилгааны тайланг хариуцсан ажилтануудаар гаргуулж байх

**Төсвийн захирагчийн хариу**

**Асуудал 2: Бараа материал**

**Тэргүүлэх ач холбогдол №3**

**НАГ-ЫН АЖИГЛАЛТ**

Бараа материалын дансаар дамжуулалгүй 1,000.0 мянган төгрөгийн шатахууныг зардалд шууд тусгасан нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.21 заалттай нийцэхгүй байна.

**Эрсдэлүүд**

Санхүүгийн тайлангийн тодруулга буруу илэрхийлэгдэх, бараа материал шамшигдах

**НАГ-ЫН ЗӨВЛӨМЖ**

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын дагуу залруулах бичилт хийх.

**Төсвийн захирагчийн хариу**

**Асуудал 3: Өглөг**

**Тэргүүлэх ач холбогдол №3**

**НАГ-ЫН АЖИГЛАЛТ**

Цалин хөлс, тээврийн хөлсний үүссэн тооцоог тухай бүрд нь журнаалд бичилгүй, улирлын эцэст бөөн дүнгээр тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2. “санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх” заалтыг зөрчиж байна.

**Эрсдэлүүд**

Тухайн гүйлгээ гарсан хугацаа буруу илэрхийлэгдэх

**НАГ-ЫН ЗӨВЛӨМЖ**


Гарсан ажил гүйлгээг тухай бүрд нь бүртгэж байх.

**ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН ХАРИУ**

**ХЯНАСАН:**

ДЭД ДАРГА  
АУДИТЫН МЕНЕЖЕР

**МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ**



Т.САРАНТУЯА  
Ц.ХОСЖАРГАЛ

2015.03.12  
2015.03.11

**БЭЛТГЭСЭН:**

АХЛАХ АУДИТОР



Ц.САРАНЦЭЦЭГ

2015.03.11